

МОНГОЛБАНК-нд

Ариг банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Түвшинтамиын ажлын тайлан

2023 оны 01 дүгээр улирал

2023 оны 03 дугаар
сарын 31-ны өдөрУлаанбаатар
хот

Ажлын тайлан

Миний бие Д.Түвшинтамир нь “Ариг банк” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн, Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар өнгөрсөн хугацаанд ажиллаа.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн ээлжит, ээлжит бус хурлууд, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хорооны хуралд оролцож холбогдох хурлыг удирдаж, тогтоолын төсөл, шийдвэр, дүгнэлт, асуудалд саналаа өгч ажилласан. Хүснэгтээр харуулбал:

Хуралд оролцсон байдлаар №1:

№	Хувьцаа эзэмшигчдийн хурал	ТУЗ-ийн хурал	Аудитын хорооны хурал	Эрсдэлийн хорооны хурал	Хүний нөөц, цалин урамшууллын хороо	Нийт оролцсон хурал
1.	-	5	2	1	1	9

Хурал хуралдсан огноогоор №2:

№	Хувьцаа эзэмшигчдийн хурал	ТУЗ-ийн хурал	Аудитын хорооны хурал	Эрсдэлийн хорооны хурал	Хүний нөөц, цалин урамшууллын хороо
1.		2023-01-18 2023-03-13 2023-03-16 2023-03-24 2023-03-30	2023-02-27 2023-03-24	2023-03-06	2023-03-27

Хараат бус гишүүнээр хуралд заавал санал өгсөн байдлаар №3:

№	Сонирхлын зөрчилтэй асуудал	Их хэмжээний хэлцэлтэй холбоотой асуудал
1.	4	1

Тайлант хугацаанд танхимаар болон цахимаар 9 удаа хуралдсан бөгөөд банкны Эрсдэлийн удирдлагын хорооны хурлыг 1 удаа даргалан оролцож, санал зөвлөмжөө өгч, шийдвэр гаргалтанд оролцсон бөгөөд дараах асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:

ТУЗ-ийн гишүүний хувьд:

1. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг чөлөөлөх, шинээр томилох;
2. Банкны 2023 оны бүтэц, орон тоо, орлого, зардлын болон хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөө батлах, өөрчлөлт оруулах, батлах;
3. ХЭ-ийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
4. Банкнийг хаалттай хувьцаат компани болгох төлөвлөгөөтэй танилцах;
5. Дотоод аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, бүтэц, орон тоо, төсвийг батлах
6. Банкны Хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүн, Удирдлагын багийн ёс зүйн дүрмийг батлах
 - а. Дүрмийг хянан тохиолдуулсан
7. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Эрсдэлийн удирдлага, Хүний нөөц, цалин урамшууллын хорооны дүгнэлттэй танилцаж шийдвэрлүүлэхээр ирүүлсэн асуудлыг батлах;
 - а. Хувьцаа эзэмшигчдийн хуралд ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийн материалтай танилцах, кумулятив аргачлал болон түүнтэй холбоотой хууль, дүрэм журмын тайлбар, анхаарах зүйлсэд санал өгсөн.
8. Гүйцэтгэх захиралтай байгуулах Онцгой нөхцөл бүхий гэрээг хэлэлцүүлэн батлах
 - а. Онцгой нөхцөл бүхий гэрээг хянан, тохиолдуулсан

ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй 5 удаагийн , их хэмжээний 1 хэлцэлд зөвшөөрөл өгөхөд саналаа өгсөн.

1. Омни тех ХХК-тай гэрээ байгуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгох
2. Номин Трейдинг ХХК-тай гэрээ байгуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгох
3. Дархан хотод банкны салбарыг шинэ байршилд шилжүүлэх, гэрээ байгуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгох
4. УИД-т байрлах банкны салбарын түрээсийн гэрээг шинэчлэн байгуулах зөвшөөрлийг Гүйцэтгэх захиралд олгох
5. ORACLE лицензын эрхийг худалдан авч, гэрээ байгуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгох
6. Номин Холдинг ХХК-тай “Нууц хадгалах гэрээ” байгуулан банкны Corporate Gateway үйлчилгээ үзүүлэх, тестлэх эрхийг Гүйцэтгэх захиралд олгох

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүний хувьд:

1. Дотоод аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, бүтэц, орон тоо, төсвийг хэлэлцэн сайжруулж, өөрчлөлт оруулан ТУЗ-д танилцуулахаар дүгнэлт гаргах
2. Дотоод аудитын газрын дотоод аудиторыг жинхлэхээр дүгнэлт гаргах
3. Дотоод аудитын газрын дотоод аудиторт нэр дэвшигчийг сонгон шалгаруулж дүгнэлт гаргах
4. Дотоод аудитын газрын мэдээллийн технологийн аудиторт нэр дэвшигчийг сонгон шалгаруулж дүгнэлт гаргах
5. Мэдээллийн технологийн CISA гэрчилгээ бүхий мэргэжилтэнтэй ажил үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах тухай дүгнэлт гаргах
6. Банкны Дотоод аудитын болон Дотоод хяналтын газрын бүтцийг тодорхой болгох үүднээс ажил үүргийг тусгайлан заавар, зөвлөгөө өгөх
7. Дотоод аудитын газрын ээлжит шалгалтын удирдамжид санал дүгнэлт өгөх
8. Банканд хийгдэж буй хөндлөнгийн аудитын үйл ажиллагааны явцын талаарх мэдээлэл авах, үнэлэлт дүгнэлт өгөх

ТУЗ-ийн дэргэхэд Эрсдэлийн удирдлагын хорооны даргын хувьд:

1. Эрсдэлийн бодлогыг шинэчлэн батлуулахаар дүгнэлт гаргах

2. Холбогдох хөтөлбөрүүдийг батлах хугацаатай үүрэг даалгавар өгөх,
3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой дотоод хяналтын хөтөлбөр гаргах үүрэг өгөх, эцсийн өмчлөгчийн тодорхойлоход авч хэрэгжүүлэхэд даалгавар өгөх
4. Банканд бүргэлтэй ашгийн төлөө бус байгууллагын талаарх тайлан мэдээтэй танилцах

ТУЗ-ийн дэргэхэд Хүний нөөц, цалин урамшууллын хорооны гишүүний хувьд:

1. ТУЗ-ийнн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулалтын зар, тавигдах шаардлагыг хянах,
2. Дотоод аудиторт нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалтад санал өгөх,
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд кумулятив аргачлалыг хэрхэн хууль, журамд нийцүүлэн ашиглах талаар зөвлөмж өгөх

ТУЗ-н хараат бус гишүүний хувьд дараах зарчим, зорилтуудад Банк анхаарлаа хандуулж байгааг онцлон хэлмээр байна.

- ТУЗ-н үйл ажиллагаа нь бодлого боловсруулагчаас гаргасан хууль тогтоомжийн дагуу явагддаг.
- ТУЗ болон хороодоор хэлэлцүүлэгдэж буй асуудалд хуулийн болон эрсдэлийн дүгнэлтийг гаргуулах, танилцуулгын чанарыг сайжруулахад анхаарч ажиллахыг Гүйцэтгэх удирдлага анхааруулдаг.
- Монголбанкнаас ирүүлсэн мэдэгдэлийн дагуу шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь хэрэгжүүлж эргэн тайлагнадаг,
- ТУЗ-с засч залруулах боломжтой асуудлууд байгаа тохиолдолд бид ТУЗ-н түвшинд хэлэлцүүлгийг эхлүүлж, үйл ажиллагааг хэрхэн сайжруулах талаар удирдамж өгч, эргэн тайлагнах хугацааг өгдөг. Удирдлагын баг эдгээр хүсэлтийг дагаж мөрдөж, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авдаг.
- Тайлангийн хугацаанд Банкны хараат бус гишүүний хувьд банкинд сөргөөр нөлөөлөхүйц буруу зүйл илрүүлээгүй тул ямар нэгэн тодорхой асуудлаар ээлжит бус хурал зарлах шаардлага гаргаагүй.
- ТУЗ нь гаргасан шийдвэр, үндэслэлийн талаар ил тод байж, цаг тухайд нь мэдээлдэг.
- ТУЗ-ийн хуралдаан дээр хараат бус гишүүний хувьд бусад гишүүдтэй зарчмын зөрүүтэй байр суурь илэрхийлэгдээгүй бөгөөд хэрэв надад асуулт байгаа эсвэл нэмэлт тодруулга авах шаардлагатай бол ТУЗ болон Удирдлагын багаас зохих мэдээллийг авдаг.
- Мөн эдгээр хурлуудаар хэлэлцүүлсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хуульд заасан байдлаар шийдвэрлэж, саналаа өгч баталгаажуулсан болно.
- Тайлангийн хугацаанд ТУЗ-с гаргасан бүх шийдвэрийг санал хураалтад миний зүгээс сайтар судалж, хуульч хүний хувьд байнга хууль, эрх зүйн зөвлөмж өгч, дэмжсэн саналтай болохыг үүгээр баталж байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 5176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу ажлын тайлангаа тайлагнав.

ТУЗ-ийн гишүүд болон түүний дэргэдэх хороодын зүгээс засаглалын тогтолцоог сайжруулах, хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, эрх тэгш байдлыг хангах, хурлаар хэлэлцэх асуудлын мэдээллийг дүрэмд заасны дагуу цаг хугацаанд хүргэх, хурлын товыг тогтооход МУ-д мөрдөгдөж буй хууль, журамд үйл ажиллагаагаа нийцүүлэн ТУЗ-с гарч буй тогтоолын хууль зүйн найруулгыг хянан ажиллаж байна.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны дүрэмд заасан хараат бус гишүүний эрх, үүргээ хэрэгжүүлэн бие даасан, хараат бус, хууль эрх зүйн чиглэлээр онцгойлон мэргэшсэн байх зарчмыг барьж ажиллаж ирсэн болно.

Тайлан бичсэн:

Ариг банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн,

Эрсдэлийн удирдлагын хорооны дарга,

Аудитын хорооны гишүүн



Д.Түвшинтамир